



УЛААНБААТАР
ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2021 оны 09 сарын 01 өдөр

Дугаар 5/2021

Улаанбаатар хот

Л.Энхбаярыг ажлаас чөлөөлж,
тэтгэмж олгох тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.8, 38 дугаар зүйлийн 38.1.1, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3.3, Компанийн Хөдөлмөрийн дотоод журмын 4 дүгээр зүйлийн 4.23, Компанийн Захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан 2019-2020 онд мөрдөх Хамтын гэрээний 5 дугаар зүйлийн 5.14 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан Зуунмод түгээх төвийн Шуурхай үйлчилгээний хэсгийн ээлжийн ахлах монтер Лодоншаравын Энхбаяр /125049/-ыг 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс үүрэгт ажлаас нь чөлөөлж, хөдөлмөрийн гэрээг цуцалсугай.

2. Л.Энхбаярт эрчим хүчний салбарт 34 жил ажилласны тэтгэмжийг эрчим хүчний салбарт ажилласан жил тутамд салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ /672000 төгрөг/-г 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр тооцож 45 696 000 /дөчин таван сая зургаан зуун ерөн зургаан мянга/ төгрөгийн нэг удаагийн тэтгэмжийг олгосугай.

3. Л.Энхбаярын ажлыг хүлээлцүүлж, ээлжийн амралтын олговрыг 2.75 хоногоор олгох, холбогдох тооцоог хийж дуусгахыг Зуунмод түгээх төвийн дарга /Д.Цолмон/-д үүрэг болгосугай.

4. Л.Энхбаярт нэг удаагийн тэтгэмжийн 45 696 000 /дөчин таван сая зургаан зуун ерөн зургаан мянга/ төгрөг олгохыг Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч /О.Ариунболд/-д зөвшөөрсүгэй.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга /Б.Баттүшиг/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Р.ДАГДАН